

## “Монгео” ХК-ийн 2020 оны үйл ажиллагааны тайлан

Компани нь тайлант хугацаанд Монгол Улсад мөрдөгдөж буй “Компанийн тухай хууль” болон бусад хуулиуд, Санхүүгийн Зохицуулах Хорооноос болон Хөрөнгийн Биржээс баталсан журам, үүрэг даалгавар, компанийн дүрэм болон дотоод журам, компанийн 2019 оны Хувь Нийлүүлэгчдийн хурлаас гарсан шийдвэр болон ТУЗ-ийн хурлын шийдвэрүүдийг хэрэгжүүлэн ажиллах зорилгыг өмнөө тавин үйл ажиллагаагаа явуулж ирлээ.

“Монгео” ХК нь “ҮЦТХадгаламжийн төв” ХХК-тай үнэт цаасны хадгаламжийн гэрээг хугацаанд нь байгуулан төлбөр тооцоог цаг алдалгүй барагдуулан хамтран ажиллаж байна.

Удирдах дээд байгууллага, Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржтэй хамтран ажиллаж тэднээс ирүүлсэн албан тоот, удирдамжыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллалаа.

Тус компани 2020 онд 8 хүний бүрэлдэхүүнтэй ажилласан. Дэлхийн дийлэнхи орныг эзэгнэсэн цар тахлын үеийн Засгийн Газар, Улсын Онцгой Байдлын газар, Нийслэлийн Онцгой Байдлын газар, Эрүүл Мэндийн Яамнаас гаргасан онцгой болон өндөржүүлсэн бэлэн байдлын хөл хорионы дэглэм, халдвар хамгааллын дэглэмийг баримтлан ажилласан болно. Өндөржүүлсэн болон хатуу хөл хорионы үед компанийн ажиллагсад / харуулуудаас бусад / цахимаар үйл ажиллагаагаа явуулсан.

Харин объектийн харуулуудад хөл хорионы үеийн ажиллах удирдамж, зөвлөмжийг боловсруулан мөрдүүлж ажилласан билээ. Компанийн ажиллагсад өөрсдийн ажил үүргийн дагуу ажил үүргээ гүйцэтгэж ирлээ.

Тус компани нь өөрийн үндсэн үйл ажиллагааны геологийн хайгуулын бүх төрлийн ажил, газар тариалан, гадаад дотоод худалдаа, аялал жуулчлал, иргэний болон үйлдвэрлэлийн барилга угсралтын зураг төсөл боловсруулах, угсралт хийх, геодези зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх чиглэлээр үйл ажиллагаагаа явуулсангүй, зөвхөн өөрийн эзэмшлийн өрөөнүүдийг аж ахуй нэгж болон иргэнд түрээслүүлэн салбар салбарын хүмүүст ажлын байр бий болгох үйл ажиллагааг явуулж байна. 2020 онд компанийн барилгын 12 -273 мкв талбай бүхий өрөөнүүдийг үйлдвэрлэл үйлчилгээний зориулалтаар 10 аж ахуй нэгж, 2 иргэнтэй түрээсийн гэрээ хийж ажилласан байна. Сар бүрд бүрэлдэх түрээсийн орлогыг цаг хугацаанд нь төвлөрүүлж компанийн ажиллагсдын цалин урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэл, бүх төрлийн татварыг боломжоороо төлөх, сар бүр хэрэглээний цахилгаан, халуун хүйтэн ус, дулаан, хог хаягдлын төлбөрийг төлж

барагдуулахад зарцуулж байна. Зээлийн үлдэгдэл байсныг төлж барагдуулсан. Компанийн эзэмшлийн СХДболон , ХУДүүрэгт байрлал бүхий 4303 мкв, 8,08 га газруудын жилийн төлбөрийг үлдэгдэлгүй төлж барагдуулсан болно. Тайлант хугацаанд компани түрээсийн орлогоос /97,024,375 төгрөг / , хамтран ажиллах гэрээгээр 8.400.000 / найман сая дөрвөн зуун мянган төгрөг / нийт //105,424,375 /төгрөгийг төвлөрүүлж үйл ажиллагаатай холбоотой зардлуудыг төлж барагдуулан ажилласан байна. “Монгео” ХК-нь “Хан Богд Ираета “ ХХК-тай хөрөнгө оруулалт хийж хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллалаа. Үүний үр дүнд газрын төлбөрийн үлдэгдэлгүй зарим нэг төрлийн татварын өрийг тэглэн ажилласан билээ.ХУД-ийн Газрын Албанаас ирүүлсэн шаардлагыг хэрэгжүүлэх зорилгоор компанийн эзэмшлийн газарт 22,800,000/ хорин хоёр сая найман зуун мянган / төгрөгийн өртөг бүхий хашаа барьж, кадастрын зураглалыг шинэчлэн хийлгэлээ.

Түрээсийн орлого маань тэртээ 2006 оноос үлдэгдэл хуримтлагдсан олон төрлийн татварын өрийг гүйцэд төлж барагдуулахад хүрэлцэхгүй, үндсэн үйл ажиллагааны чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж чадахгүй байгаа зэргээс улбаалан ашигтай бус алдагдалтай ажиллаж байгаа болно. Иймээс бид Хувь Нийлүүлэгчдэд ногдол ашиг хуваарилж чадахгүй байгаа юм. 2020 онд компани санхүү , татварын , нийгмийн даатгалын шимтгэлийн татварын тайлангуудыг заасан цаг хугацаанд нь үйлдэн холбогдох байгууллагуудад тайлагнан хоцрогдол алдангигүй ажиллаж байна. ТУЗ-ийн хурлын шийдвэрийг үндэслэн шаардлага хангасан тусгай зөвшөөрөлтэй “ Б ЭНД СИ” аудит ХХК-иар хяналт хийлгэн дүгнүүлсэн болно. Өнгөрсөн оны хувь нийлүүлэгчдийн хурлаас гаргасан шийдвэрүүдийг ханган ажиллалаа. Тайлант хугацаанд хуримтлагдсан байсан НӨАТ-ын үлдэгдлээс 7,423,322, ХХОАТ-ын үлдэгдлээс 3,765,153 төгрөгийг ҮХЭХАТ –ын үлдэгдлээс 927690 төгрөгийг тус тус төлж барагдуулсан байна.

Компанийн эзэмшлийн барилгын өрөөнүүдийг зохистой байдлаар түрээслэх , бизнес эрхлэх төлөвлөгөө , судалгаа , тооцоог нарийвчлан гаргахаар ажиллаж байна. Хурлаас гарах санал, тогтоол шийдвэрүүдийг хүндэтгэн үзэж, хүлээн авч компанийн үйл ажиллагааг чиглүүлэн ажиллах шаардлагыг ханган ажиллана.

КОМПАНИЙН ЗАХИРГАА